МЭДЭЭ · 2020 оны 1-р сарын 31

МЭДЭГДЭЛ



МЭДЭГДЭЛ

“Үндэсний шуудан” сонины 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн №18/3483/ дугаарт болон eguur.mn сайтад нийтлэгдсэн “Дундговь аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, прокурорын дарга С.Гансэлэм нарыг шалгаж байна” гарчигтай нийтлэлийн мөрөөр Улсын ерөнхий прокурорын газрын Дотоод хяналт, шалгалтын хэлтсээс холбогдох шалгалтыг явуулахад худал ташаа мэдээлэл болох нь тогтоогдлоо.

Дундговь аймгийн прокурорын газрын ерөнхий прокурор С.Гансэлэмийг “илтэд хууль бус шийдвэр гаргасан, эрх мэдэл албан тушаалаа урвуулан ашиглаж, бусдаас авлига авсан эсэхийг шалгаж тогтоохоор болсон, Авлигатай тэмцэх газраас С.Гансэлэмд эрүүгийн хэрэг үүсгэн шалгах хүсэлт хүргүүлсэн” гэдэг нь ор үндэслэлгүй, худал мэдээлэл болно.

Дээрх нийтлэл нь прокурорын нэр төр, алдар хүндэд болон прокурорын байгууллагын ажил хэргийн нэр хүндэд халдсан, хараат бус байдалд нөлөөлсөн агуулга бүхий байх тул “Үндэсний шуудан” сонины редакцид ташаа мэдээллийн талаар сониноороо дамжуулан “Залруулга” хийхийг шаардсан албан бичиг хүргүүлж, мөн хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчигдөж байна гэж үзээд Монголын Хэвлэл Мэдээллийн зөвлөлд хандсан болохыг үүгээр мэдэгдэж байна.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР